



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар A/53

Арвайхээр

**Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц орон  
тооны дээд хязгаарыг тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 –ын “б” дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.3. дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллаганы чиглэлийг батлах тухай” 415 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх “Эрүүл мэндийн газрын дүрэм”-ийг нэгдүгээр, бүтэц орон тооны дээд хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүрэм, бүтэц орон тооны дээд хязгаарыг мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан “Эрүүл мэндийн газрын дүрэм батлах тухай” аймгийн Засаг даргын 2015 оны а/150 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100128

Аймгийн Засаг даргын 2019... оны 01  
дугаар сарын 29-ны өдрийн 453 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

## АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (цаашид Эрүүл мэндийн газар гэх)-ын бүрэн эрх, чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аймгийн Засаг даргын шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж, стандартыг мөрдлөг болгоно.

1.3. Эрүүл мэндийн газар нь нэн түрүүнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэлээ болгон, эрүүл мэндийн байгууллагууд болон бусад салбарууд, иргэдийн хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангахад нэгдмэл удирдлагаар хангаж ажиллана.

1.4. Эрүүл мэндийн газар нь иргэдээ дээдэлсэн, тэгш, хүртээмжтэй, чанартай, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангах, үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй, ил тод, иргэдийн оролцоог хангасан байх зарчмыг баримтална.

### Хоёр. Үйл ажиллагааны чиглэл

Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдох асуудлаар:

2.1.1. Өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар дэд хөтөлбөр, төлөвлөлт хийх, шийдвэр гаргах аймгийн Засаг даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах

2.1.2. Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх эрүүл мэндийн үйл ажиллагаанд бусад салбар, иргэдийн оролцоог хангах

2.1.3. Хүн амын эрүүл мэндтэй холбогдон гарсан бодлого, хөтөлбөр, тушаал шийдвэрийг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллага болон орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлан таниулж хэрэгжилтийг зохион байгуулах

2.1.4. Эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн түвшинд эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах

2.1.5. Үйлчлүүлэгч төвтэй чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээг нэвтрүүлэх талаар онцгойлон анхаарч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тусламж үйлчилгээтэй холбогдон гарсан иргэдийн санал, хүсэлт, гомдлыг барагдуулах шийдвэрлэх

2.2. Эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар:

2.2.1. Өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудлаар санал, дүгнэлт гаргах

2.2.2. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амынхаа эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, төрийн хүчин чадлаас давсан тусламж үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохицуулах, төлөвлөлт хийх

2.2.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өөрийн орон нутгаас тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага болон төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран хувийн хэвшлийн хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

2.3. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих чиглэлээр:

2.3.1. Эрүүл мэндийн байгууллагыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарсан стандарт, тусламж үйлчилгээний багц, удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэнд хяналт тавих

2.3.2. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн нөлөөг судлах судалгаа хийх, зөвлөмж гаргах

2.3.3. Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан, орон нутгийн засаг захиргааны байгууллагын хяналттайгаар зохицуулах, хуваарилах

2.3.4. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг санхүүгийн удирдлагаар хангах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн мэдээ, тайланг нэгтгэх, үнэлэлт, дүгнэлт өгөх

2.4. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх асуудлаар:

2.4.1. Эрүүл мэндийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хүн амын эрүүл мэндийн талаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлоход шаардлагатай мэдээ, мэдээллээр холбогдох байгууллагуудыг цаг тухайд нь шуурхай хангах

2.4.2. Өөрийн харьяа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амын өвчлөл, эндэгдлийн талаарх мэдээг цаг тухайд нь хүлээн авч нэгтгэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг эргэн мэдээллээр хангах

Гурав. Удирдлага зохион байгуулалт:

3.1. Аймгийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Төсвийн тухай хуулийн 6.3.3-д заасны дагуу эрх, үүргээ Эрүүл мэндийн газрын даргад шилжүүлж болно.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч эрхээ шилжүүлж ажилласнаар Төсвийн тухай хуулийн

22.6.5 дахь заалтын дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын дарга орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын даргатай гэрээ байгуулан ажиллана.

3.3. Эрүүл мэндийн газар нь аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд "Эрүүл мэндийн газар" гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

3.4. Эрүүл мэндийн газар нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүү хөрөнгө нөөцийг хуваарилах, хяналт тавих асуудлыг хариуцаж, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн сайдад тайлагнана.

3.5. Өөрийн бүтцэд "Нийгмийн эрүүл мэндийн төв"-ийг байгуулан ажиллаж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж хяналт тавина.

Дөрөв. Эрх, үүрэг

4.1. Эрүүл мэндийн газрын эрх:

4.1.1. Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ.

4.1.2. Харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үүрэг, даалгавар өгч биелэлтийг шаардах, хариуцлага тооцох

4.1.3. Өөрийн харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага ажилтнуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, урамшуулан дэмжих чиглэлээр төр олон нийт, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, төрийн одон, медаль, салбарын болон нутгийн захиргааны байгууллагын шагналд нэр дэвшүүлэх, шийдвэрлүүлэх

4.1.4. Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээрх үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулах, тус үйл ажиллагаанд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах

4.1.5. Хуульд заасан эрхийн хүрээнд Эрүүл мэндийн газрын ажилтныг томилох, чөлөөлөх, албан тушаалаас нь бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр чөлөөлөх, халах

4.1.6. Эрүүл мэндийн чиглэлээр эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг зохион байгуулах

4.1.7. Эрүүл мэндийн байгууллагад гарсан шинэ бүтээл, дэвшилтэт технологид дүгнэлт гаргах, санал өгөх

4.1.8. Орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийн байдалд хяналт тавих, шаардлагатай мэдээ мэдээллийг гаргуулан авах

4.2. Эрүүл мэндийн газрын үүрэг:

4.2.1. Энэхүү дүрмийн 3.2-т заасны дагуу аймгийн Засаг дарга эрхээ шилжүүлсэн тохиолдолд аймаг, сумын нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг,

сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гэрээний биелэлтийг Засаг даргын өмнө хариуцна.

4.2.2. Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрх зүйн акт, стандарт, удирдамж, тусламж үйлчилгээний багц, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг хэрэгжүүлэх

4.2.3. Аймгийн Засаг даргаар ахлуулсан "Эрүүл мэндийн салбар зөвлөл"-ийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж хурал зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэн бэлтгэх

4.2.4. Хүн амын эрэлт хэрэгцээг үндэслэн, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, тасралтгүй байдлыг хангах, төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохистой бүрдлийг бий болгоход эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг тодорхойлох

4.2.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран гүйцэтгэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийж, тэргүүлэх чиглэлээ тогтоож, түншлэлийн чиглэл, хэтийн төлөвийг тодорхойлох

4.2.6. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

4.2.7. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний талаарх иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тодорхой давтамжтайгаар авч мэдээлэх, судалгааны мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4.2.8. Төлбөртэй тусламж үйлчилгээний үнэ тарифыг иргэдэд ил тод, нээлттэй байлгах арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавих

4.2.9. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй нөлөөллийн үнэлгээ болон эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагатай хамтран хийж үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох дээд шатны байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх

4.2.10. Хүн амын өвчлөлийн чиг хандлага, эмнэлгийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулж өөрийн орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийх, харьяа эрүүл мэндийн байгууллагын хөрөнгийн бүртгэлийн мэдээний санг байгуулан, тогтмол шинэчлэх,

4.2.11. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хангамжийн асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулах

4.2.12. Эм хангамжийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах

4.2.13. Харьяа эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ, гүйцэтгэлийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

4.2.14. Харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт хийх

4.2.15. Харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг хүний нөөцөөр хангах үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулах

4.2.16. Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчинг бүрдүүлэх, сургалт зохион байгуулах нөхцөлөөр хангах

4.2.17. Эрүүл мэндийн байгууллагын, ажиллагсдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээг зохион байгуулах

4.2.18. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа доголдлыг бүртгэн мэдээлэх

-oOo-

Аймгийн Засаг даргын 2019..... оны .01  
дугаар сарын 29 ны өдрийн 4/53 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

Эрүүл мэндийн газрын дарга-1

### **Нэг. Удирдлага төлөвлөлтийн хэлтэс, орон тоо-7**

1. Хэлтсийн дарга, эрүүл мэндийн удирдлага, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн-1
2. Хууль эрх зүй, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн-1
3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал, ёс зүй хариуцсан мэргэжилтэн -1
4. Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн-1
5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1
6. Архив, бичиг хэргийн ажилтан-1
7. Олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан-1

### **Хоёр.Эмнэлгийн тусламжийн хэлтэс, орон тоо- 7**

1. Хэлтсийн дарга, эмнэлгийн тусламжийн чанар, магадлан итгэмжлэл, оношлогоо, эмчилгээ, технологи мөрдөлт, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн-1
2. Яаралтай гамшгийн үеийн тусламж, лаборатори, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн-1
3. Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж хариуцсан мэргэжилтэн -1
4. Нөхөн үржихүй, өсвөр үеийнхний эрүүл мэндийн тусламж хариуцсан мэргэжилтэн-1
5. Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн-1
6. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж хариуцсан мэргэжилтэн-1
7. Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн-1

### **Гурав. Хяналт- шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс, орон тоо-4**

1. Хэлтсийн дарга, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн-1
2. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн-1
3. Статистик мэдээллийн ажилтан-1
4. Мэдээллийн технологи, телемедицин хариуцсан мэргэжилтэн -1

### **Тав. Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс, орон тоо-7**

1. Хэлтсийн дарга, НЭМ-ийн удирдлага, зохион байгуулалт, амьсгалын замын халдвар, сүрьеэ, дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн -1
2. Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ахмад настны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1
3. Орчны эрүүл мэнд, Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ, гэдэсний халдварт өвчин, голомтын ариутгал халдваргүйтгэл, бэлгийн замаар дамжих халдварын тандалт, сэргийлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар хариуцсан мэргэжилтэн-1
4. Дархлаажуулалтын мэдээ, мэдээлэл хүйтэн хэлхээ хариуцсан ажилтан-1

5. Халдварт бус өвчний тандалт, сэргийлэлт, хяналт, хавдрын эрт илрүүлэг, тандалт, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1
6. Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1
7. Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн-1

**Дөрөв. Захиргаа, санхүү, нийтлэг үйлчилгээний алба, орон тоо- 12**

1. Албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч-1
2. Эдийн засагч-1
3. Нягтлан бодогч-1
4. Даргын туслах-1
5. Жолооч-2
6. Үйлчлэгч-2
7. Жижүүр-4

**Бүгд орон тоо – 38**

1. Эрүүл мэндийн газрын дарга -1
2. Удирдлага төлөвлөлтийн хэлтэс-7
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс -7
4. Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээллийн хэлтэс -4
5. Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс -7
6. Захиргаа, санхүү, нийтлэг үйлчилгээний алба -12